



БОЛОВСРОЛЫН  
ЯАМ



германы  
хамтын ажиллагаа  
DEUTSCHE ZUSAMMENARBEIT



Хэрэгжүүлэгч:  
giz Deutsche Gesellschaft  
für Internationale  
Zusammenarbeit (GIZ) GmbH



# ТҮНШЛЭЛД СУУРИЛСАН ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТ-II ТӨСӨЛ

## ТӨСЛИЙН ТУХАЙ:

Ур чадвартай ажиллах хүч нь эдийн засгийн хөгжлийн гол түлхүүр юм. Монгол Улсад аж үйлдвэрлэл, үйлчилгээний салбар хөгжихийн хэрээр хөдөлмөрийн зах зээлд техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт (ТБМБС)-аар бэлтгэгдсэн мэргэжилтэй ажилтны эрэлт нэмэгдсээр байна. Хувьсан өөрчлөгдөж буй өнөө үед ТБМБС-ын тогтолцоо нь ирээдүй рүү чиглэсэн ур чадварыг эзэмшүүлдэг, үр ашигтай, хүртээмжтэй бөгөөд уян хатан байх шаардлага нэмэгдсээр байна.

Төсөл нь Монгол Улсын ТБМБС-ын тогтолцоонд шинэчлэл хийхэд Боловсролын Яамыг дараах агуулгуудын хүрээнд дэмжин ажиллаж байна. Үүнд:

- Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх
- ТБМБС-ын хосмог тогтолцоог бий болгоход шаардлагатай байгууллага болон хүний нөөцийг чадавхжуулах
- Жендэрийн мэдрэмжтэй сургалтын орчныг бий болгох
- Сэргээгдэх эрчим хүчний салбар дахь мэргэжилтэн бэлтгэх сургалтыг эхлүүлэх

Энэхүү шинэчлэл нь ажил олгогчид болон аж ахуйн нэгж байгууллага (АНБ), хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн, үр ашигтай МБС-ыг бий болгоход чиглэж байна.

## ЗОРИЛГО:

ТБМБС-ын тогтолцооны шинэчлэлийн гол бүрэлдэхүүн хэсгүүдийг эхлүүлэхэд дэмжинэ.

Захиалагч ба хамтран санхүүжүүлэгч:	ХБНГУ-ын Холбооны Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Яам (BMZ)
Хамтран санхүүжүүлэгч:	Австралийн Гадаад Хэрэг, Худалдааны Яам (DFAT)
Төсөл хэрэгжих бүс, нутаг:	Улаанбаатар ба сонгогдсон аймгууд
Хэрэгжүүлэгч байгууллага:	Боловсролын яам
Хугацаа:	2024/01 – 2026/06



Гүйцэтгэлд суурилсан  
санхүүжилт



Хосмог ТБМБС



Жендэрийн  
мэдрэмжтэй  
сургалтын орчин



Сэргээгдэх эрчим  
хүчний сургалт



1 ядуурлыг  
устгах



4 ЧАНАРТАЙ  
БОЛОВСРОЛЫГ  
ДЭМЖИХ



5 ЖЕНДЕРИЙН ЭРХ  
ТЭГШ БАЙДЛЫГ  
ХАНГАХ



8 зохиистой хөдөлмөр  
ба эдийн засгийн  
өсөлтийг дэмжих



10 ТЭГШ БУС  
БАЙДЛЫГ  
БУУРУУЛАХ



13 УУР АМЬСГАЛЫН  
ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР  
НӨЛӨГ БАГАСГАХ



Үйлдвэрийн сургагч



Үйлдвэрлэлийн механикийн суралцагсад

## ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН



### Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн механизм (ГССМ)-ыг нэвтрүүлнэ

ГССМ-ийн давуу тал нь сургалтын чанар, үр дүнг сайжруулахад анхааран, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (KPI)-д тулгуурлаж санхүүжилт олгодог байдал юм. Сургалтын байгууллагыг үр дүн, гүйцэтгэлдээ илүү анхааран хариуцлагатай хандахад хөшүүрэг болдог нь уламжлалт санхүүжилтийн аргуудаас давуу талтай.

Төслийн хүрээнд, үр дүн, гүйцэтгэлийг үнэлэх KPI-ийг боловсруулах, үүнд жендэрт суурилсан шалгуур үзүүлэлтийг нэгтгэхэд холбогдох байгууллагуудыг дэмжин ажиллана.

#### Бидний зорилт:

- Сонгогдсон 7 ТбМБС-ын байгууллагуудад ГССМ-ийг туршилтаар нэвтрүүлэх
- Жендэрийн мэдрэмжтэй төсвийн хуваарилалтын талаарх сургалтад 20 сургалтын байгууллагын ажилчдыг хамруулах



### Жендэрийн мэдрэмжтэй сургалтын орчныг дэмжинэ

Жендэрийн мэдрэмжтэй сургалтын орчин гэдэг нь ялгаатай байдал, хэрэгцээг харгалзаж, хүртээмжтэй, ижил тэнцүү боломжийг олгодог байхаас гадна жендэрийн хэвшмэл ойлголтыг дэмждэггүй орчныг хэлнэ.

Ийм орчныг бий болгохын тулд байгууллагын хөгжлийн бодлого, сургалтын хөтөлбөр, соёлд жендэрийн ойлголтыг нэвтрүүлэх зэрэг цогц стратеги шаардлагатай.

#### Бидний зорилт:

- ТбМБС-ын байгууллагуудын орчинг жендэрийн мэдрэмжтэй болгох
- Сургалтын байгууллагын жендэрийн үнэлгээний үр дүн 20 сургуулиас, хамгийн багадаа 12 нь сайжирсан байхаар үнэлүүлэх



### Хосмог ТбМБС-ыг хэрэгжүүлэх хүний нөөцийг бэлтгэнэ

Ажлын байр болон сургалтын байгууллага дээр суралцах боломжтой хосмог ТбМБС-ын тогтолцоог хэрэгжүүлэх хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд төсөл дэмжиж байна.

ААНБ болон сургалтын байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнд ажлын байран дээрх ур чадварын хэрэгцээг тодорхойлох, шинэ техник технологийн дэвшилд нийцсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулах боломжтой. Хосмог ТбМБС-ыг хэрэгжүүлэхэд ААН дэх ажлын байран дээрх сургагч болон ТбМБС-ын байгууллага дахь нийгмийн түншлэлийн ажилтнуудын оролцоо нэн чухал юм.

#### Бидний зорилт:

- ААН дэх дадлагажуулагч багш бэлтгэх 20 мастер сургагчийг бэлтгэж, эрх бүхий байгууллагаар гэрчилгээжүүлэх
- Нийгмийн түншлэлийн 35 мэргэжилтний чадавхыг бэхжүүлэх



### Сэргээгдэх эрчим хүчний хосмог сургалтыг эхлүүлнэ

Тогтвортой эрчим хүчний хэрэгцээ улам бүр нэмэгдэж буй энэ цаг үед, сэргээгдэх эрчим хүчний салбарт ажиллахад шаардлагатай мэргэжилтнүүдийг бэлтгэхэд төсөл хувь нэмрээ оруулж байна.

#### Бидний зорилт:

- Сэргээгдэх эрчим хүчний 3 хосмог сургалтын хөтөлбөрүүдийг аж ахуйн нэгжтэй хамтран боловсруулна.

Нийтэлсэн:

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг

Холбоо барих:

Д.Оюунаа (Төслийн удирдагч)  
"Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт-II" (ТСТМБС – II)  
Найман зовхис барилгын IV давхар, Сөүлийн гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14251, Монгол улс



Утас:  
И-мэйл:  
Веб:

(+976) 70005340  
damiinyam.oyunaa@giz.de  
www.giz.de/mongolia

Огноо:

2024 оны 8-р сар

Дизайн/Зураг:

Монгол дахь GIZ  
Нийтлэлийн агуулгыг Монгол дахь  
GIZ хариуцна.

Хамтран  
хэрэгжүүлэгч:

Боловсролын яам

Захиалагч:

ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа  
хөгжлийн яам (BMZ)